



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 01/303

Арвайхээр сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Мобиком корпораци” ХХК-ийн захиалгаар Өлзийт сумын 3 дугаар багийн Өлзийт хайрхан уул, Хужирт сумын Уужим багийн Дуулгат уул, Баянгол сумын Өндөр өнц багийн Улаанчих уул, Зүүнбаян-Улаан сумын Эмгэд багийн Баянзүрх уул, Уянга сумын Өлт багийн Буурал хайрхан уул, Бадрал багийн Он ацын нуруунд байрлах үүрэн холбооны сайтын угсралтын ажил дууссан тул “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу дунд төвөгшилтэй барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дарга (А.Энхцэцэг)-д даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0576

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 10 -ны өдрийн 10/10 дугаар
захирамжийн хавсралт

**ДУНД ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга: А.Энхцэцэг (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

С.Нямдорж (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)

Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ц.Нэргүй (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн, хэлтсийн Архивын тасгийн дарга)

Б.Балжинням (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Ахмад)

Г.Гантулга ("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн Өвархангай аймгийн газрын ашиглалтын менежер)

Ашиглагч:

Б.Золхүү ("Мобиком корпораци" ХХК-ийн барилгын инженер)

Гүйцэтгэгч:

Б.Ариунтөгс ("Монхас" ХХК-ийн ерөнхий инженер)

Нарийн бичгийн дарга: Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)